

U



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/318

Зуунмод

Захирамжид өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Багийн хилийн цэсийг баталгаажуулсантай холбогдуулан Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгт боловсролын байгууллагын зориулалтаар газар эзэмшүүлэх тухай аймгийн Засаг даргын 2008 оны 321 дүгээр захирамжийн 1 дэх заалтад "...Зуунмод сумын 1-р багийн нутагт 1-р цэцэрлэг 4169 м2, 5-р цэцэрлэг 4010 м2 ..." гэснийг "... Номт 1-р баг, Солонго хотхон, Рашааны гудамж 301 тоотод 4169 м2, Баруун Зуунмод 6-р баг, Ирээдүй хотхон, Рашааны гудамж, 315 тоотод 4010 м2 газрыг тус тус ..." гэж өөрчилсүгэй.

2. Захирамжийн дагуу газар эзэмшүүлэх гэрчилгээг шинэчлэн олгохыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 0010000